

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДЭД БҮТЦИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН ДАМДИНДОРЛИГИЙН НАРАНБААТАРЫН 2025 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Биелэлтийн хувь
	1	2	Суурь түвшин 3	Хүрэх түвшин 4	Хүрсэн түвшин (биелэлт) 5	Эхэлсэн, дууссан хугацаа 6	
	Зорилт 1. “2025 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын гүйцэтгэлийг хангаж ажиллах” зорилтын хүрээнд						
1.	Арга хэмжээ 1.1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд гүйцэтгэх барилга засварын ажилд хяналт тавих, ашиглалтад хүлээж авах.	Барилга байгууламжийн засварын 12 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж ашиглалтад оруулсан тоогоор.	-	Гэрээ байгуулан ажил эхлүүлсэн байна.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” 02/12 дугаар тогтоолоор батлагдсан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламжийн засварын 12 төсөл арга хэмжээнээс 1 төсөл арга хэмжээнд улсын комисс ажиллан байнгийн ашиглалтад хүлээн авсан байна. Мөн 10 төсөл арга хэмжээнд ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажил эхлүүлсэн байна. 1 төсөл арга хэмжээнд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулхаар 5 дахь удаа тендер зарлагдаад байна.	2025.04.01-2025.12.31	100%

2.	Арга хэмжээ 1.2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд гүйцэтгэх барилга, байгууламжийн төсөл арга хэмжээнд хяналт тавих, ашиглалтад хүлээж авах.	Гучин-Ус, Богд, Баруунбаян-Улаан, Өлзийт, Уянга сумдад төрийн албан хаагчийн 5 орон сууцыг барьж ашиглалтад оруулсан тоогоор.	-	Гэрээ байгуулан ажил эхлүүлсэн байна.	Баруунбаян-Улаан суманд төрийн албан хаагчийн орон сууц барих ажилд гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт 2 дахь удаа зарлагдсан бөгөөд Баруунбаян-Улаан суманд баригдах төрийн албан хаагчийн орон сууцны гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер нээсэн үнэлгээний шатанд явж байна. Өлзийт суманд төрийн албан хаагчийн орон сууц барих ажилд гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт 2 дахь удаа зарлагдсан бөгөөд тендерийн бичиг баримт хүлээн авч байна. Богд, Гучин-Ус суманд баригдах төрийн албан хаагчийн орон сууц барих ажлыг сумдын худалдан авах ажиллагааны газарт эрх шилжүүлсэн. Уянга суманд баригдах төрийн албан хаагчийн орон сууц барих ажлыг барих сонгон шалгаруулалт зарлагдаагүй байна.	2025.04.01-2025.11.15	50%
3.	Арга хэмжээ 1.3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд гүйцэтгэх авто замын барилга байгууламжийн төсөл арга хэмжээнд хяналт тавих, ашиглалтад хүлээж авах.	Авто замын барилга, байгууламжийн 6 төсөл арга хэмжээнд хяналт тавьж ашиглалтад оруулсан тоогоор.	-	Гэрээ байгуулан ажил эхлүүлсэн байна.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Аймгийн 2025 оны төсөв батлах тухай" 02/12 дугаар тогтоолоор батлагдсан авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх "Арвайхээр сумын 9-р багийн аюулгүйн тойргоос баруун 4 зам хүртэлх 671,3 метр авто зам, явган хүний замын засвар шинэчлэл, гэрэлтүүлэг"-ийн ажил, "Арвайхээр сумын 9 дүгээр багийн багийн төвийн 1,2 км авто	2025.05.01-2025.12.31	90%

						замын засвар, шинэчлэлт"-ийн ажлыг "Хас гарьд констракшн" ХХК гүйцэтгэж байгаа ба авто замын барилга угсралтын ажил тус бүр 30 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. Арвайхээр сумын баруун 4 замын уулзварын гэрлэн дохионы шинэчлэлийн ажилд "Дэвших стандарт" ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгэгч тал ажил эхлүүлэх бэлтгэл ажлаа ханган бараа материал үйлдвэрээс татан авалт хийж байна. Хужирт, Хархорин, Бат-Өлзий, Уянга сумдын хатуу хучилттай авто замын засвар арчлалт, тэмдэг тэмдэглэгээ сайжруулах ажлыг Өвөрхангай аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/407 дугаар захирамжаар сум тус бүрийн худалдан авах ажиллагааны газарт эрх шилжүүлсэн. Арвайхээр сумын 5 дугаар сургуулийн авто зогсоол шинээр барих ажилд тендерийн шаардлага хангах аж ахуй нэгж орж ирээгүй байгаа тул сонгон шалгаруулалт дахин зарласан. Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газрын авто зогсоолын ажилд гүйцэтгэгч сонгон шалгаруулалтыг 3 удаа зарласан боловч аж ахуй нэгж оролцоогүй байна.
--	--	--	--	--	--	--

4.	Арга хэмжээ 1.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Арвайхээр суманд хийгдэж буй инженерийн шугам сүлжээний ажлуудад хяналт тавьж ажиллах.	Арвайхээр сумын хорооллын 3,8 дугаар баг, 1,9 дүгээр баг, 13, залуус хороолол, од хороолол, Согоот-1, Бурхи-9 дүгээр багуудад хэрэгжиж буй 3 төсөл хэмжээнд хяналт, тавьж ажиллах.	30%	40%	Арвайхээр суманд инженерийн шугам сүлжээний ажил нийт 55 хувийн гүйцэтгэлтэй, "Хангай илч дулаан" ХХК-ийн гүйцэтгэж буй инженерийн шугам сүлжээний ажил нийт 22 хувийн гүйцэтгэлтэй байна. "Альфа илч" ХХК нь 2024 онд шугам сүлжээний ажлыг 30 хувийн гүйцэтгэлд хүргэсэн ба хадан хөрс илэрсэн тул техник тоног төхөөрөмж сайжруулах арга хэмжээ аван ажиллаж байна. Арвайхээр суманд хийгдэж буй инженерийн шугам сүлжээний ажлын нийт гүйцэтгэл 35,3 хувийн гүйцэтгэлтэй байна.	2025.05.01-2025.11.15	50%		
5.	Арга хэмжээ 1.5. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Арвайхээр суманд хийгдсэн инженерийн шугам сүлжээний ажлуудад хяналт, шалгалт хийж баталгаат хугацаан дахь засварыг гүйцэтгүүлэх.	Улсын комисст хүлээлгэн өгсөн 2 төсөл арга хэмжээнд хяналт, шалгалт хийх.	Ашиглалтад оруулсан	50%	"Бага хөгшин" ХХК, "Мөнх урлал" ХХК-ийн түншлэл Арвайхээр сумын 10, 11 дүгээр багт хийсэн цэвэр, бохир усны шугамын ажилд баталгаат хугацаан дахь хяналт шалгалтыг ГХБХБГ-тай хамтран хийсэн бөгөөд засварлах шаардлагатай хэсгүүдийг гүйцэтгэгч талд мэдэгдэн шугамын трассын дагуух хөрсний	2025.04.20-2025.10.01	90%		

					суулыг засварлуулсан. шугам татах үед хатуу хучилттай авто замыг 2 байршилд сэтгэлсэн бөгөөд авто замын нөхөөсийг гүйцэтгүүлэхээр ажиллаж байна.			
6.	Арга хэмжээ 1.6. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам сүлжээг шинэчлэх ажил.	Ажлын гүйцэтгэлээр	-	Гэрээ байгуулан ажил эхлүүлсэн байна.	Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам сүлжээг шинэчлэх ажлын гүйцэтгэгийг сонгон шалгаруулалт хийгдэж "Энерго сервис монтаж" ХХК шалгарсан бөгөөд 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсан. Гүйцэтгэгч тал ажил эхлүүлэх бэлтгэлээ ханган ажиллаж байна.	2025.05.01-2025.12.31	90%	
7.	Арга хэмжээ 1.7. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх дулаан дамжуулах төвүүд болон дулааны станцын гадна цахилгаан хангамжийн ажил.	Ажлын гүйцэтгэлээр	40%	60%	Дулааны станцын гадна цахилгаан хангамж шинэчлэх ажлыг "Эм Ай Эс Эс" ХХК гүйцэтгэж байгаа ба гэрээт ажил нийт 47 хувийн гүйцэтгэлтэй байна.	2025.04.20-2025.12.31	50%	
8.	Арга хэмжээ 1.8. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа Бат-Өлзий, Нарийнтээл, Уянга сумын инженерийн шугам сүлжээний ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх.	Ажлын гүйцэтгэлээр	30%	50%	Нарийнтээл суманд хийгдэж буй инженерийн шугам сүлжээний ажилд нийт 12079 метр цэвэр, бохирын шугам татах бөгөөд 6213 метр цэвэр бохирын шугам татсан байна. Мөн нийт 176 ширхэг цэвэр бохир усны худаг хийгдэхээс 89 ширхэгийг гүйцэтгэж нийт ажлын гүйцэтгэл 51 хувийн гүйцэтгэлтэй байна. Уянга суманд хийгдэж буй инженерийн дэд бүтцийн хангамжийн ажилд гадна цахилгаан, гүний худаг, дулааны шугамын ажил, усан сангийн барилга байгууламжийн ажил	2025.05.01-2025.12.31	100%	

						бүрэн хийгдэж дууссан байна. Бохир усны шугамын ажлын гүйцэтгэл 50 хувьтай, цэвэрлэх байгууламжийн ажил хийгдэж эхлээгүй байна. Төслийн нийт гүйцэтгэл 78 хувьтай байна. Бат-Өлзий суманд хийгдэж буй инженерийн шугам сүлжээний ажил нийт 85 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.		
Зорилт 2. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтын хүрээнд								
1.	Арга хэмжээ 2.1. Төрийн албаны тухай хууль, ёс зүй, сахилга хариуцлагатай холбогдох дүрэм, журмыг чанд мөрдөн ажиллаж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах	Үүрэг даалгаврын биелэлтээр	-	50%	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, салбарын тоон мэдээлэл, судалгааг цаг тухай бүр шинэчлэн удирдлагыг салбарын мэдээллээр хангаж ажиллаж байна.	2025.01.03-2025.12.31	100%	
2.	Арга хэмжээ 2.2. Албан бичиг болон иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувиар	-	50%	Төрийн байгууллага болон бусад аж ахуйн нэгж, байгууллагаас албан бичгээр буй ирүүлж асуудлуудыг удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврын дагуу хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна. Мөн Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төвөөс 1, Арвайхээр сумын 7-р багийн оршин суугчийн гаргасан хүсэлтийн дагуу газар дээр нь ажиллаж мэдээллийг хэлтсийн даргад хүргэж ажилласан.	2025.01.03-2025.12.31	100%	

3.	Арга хэмжээ 2.3. Тухайн онд боловсруулан гаргах албан бичгийг монгол бичгээр хослуулан боловсруулах	Бүх албан бичгийг монгол бичгээр хослуулан гаргах	-	50%	Тайлант үеийн байдлаар гаргасан албан бичгийн нийт 90 хувийг монгол бичгээр гаргасан байна.	2025.01.03-2025.12.31	90%
4.	Арга хэмжээ 2.4 Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу ажлын хэсэгт орж ажиллах, үр дүнг танилцуулах	Үүрэг даалгаврын биелэлтээр	Ажлын хэсэг байгуулсан	1	Өвөрхангай аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/898 дугаартай Арвайхээр сумын төв бараан зах болон томоохон худалдааны төвүүдэд эрсдэлийн үнэлгээ хийж, гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангуулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон цаашид авах арга хэмжээний талаар аймгийн Засаг даргын Тамгын газрын зөвлөлийн хуралд танилцуулсан.	2025.01.03-2025.12.20	100%
Зорилт 3. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ							
1	Арга хэмжээ 3.1. Байгууллагаас болон бусад холбогдох газруудаас зохион байгуулсан сургалт, зөвлөгөөнд хамрагдсан байх	Сургалтад хамрагдсан байдал	-	2	Аймгийн ЗДТГ, ГХБХБГ, "Хөгжлийн төлөө" барилгачдын холбоо, Политехник коллежийн хамтаран зохион байгуулсан "Орон сууцжуулалт, дэд бүтэц" сэдэвт барилгын инженер, техникийн болон удирдлах ажилтаны сургалт, зөвлөгөөнд 2025 оны 03 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд оролцсон. "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал", Хангайн бүсийн зөвлөгөөнд 4 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд оролцсон.	2025.01.03-2025.12.31	100%

2	Арга хэмжээ 3.2. Монгол бичгээр албан бичиг боловсруулах, хөрвүүлэх программыг ашиглаж, суралцах	Суралцсан байдал	Хөрвүүлэх программ суулгах	50%	Крилээс монгол бичиг рүү хөрвүүлэх программыг ашиглан албан бичиг боловсруулж сурсан.	2025.01.03-2025.12.31	100%
---	--	------------------	----------------------------	-----	---	-----------------------	------

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хотуудад агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр орчин үеийн дэвшилтэт техник, технологийн туршлага судлах.				Аймгийн Засаг даргын А/1001 дугаартай захирамжийн дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хотуудад туршлага судлах, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр орчин үеийн дэвшилтэт техник, технологийн судалгааны ажлаар 2025 оны 03 дугаар сарын 10-аас 03 дугаар сарын 15-ны өдрүүдэд зуухны үйлдвэртэй танилцаж туршлага судалж ажилласан.	2025.03.10-2025.03.15	100%
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. "Нийтийн эзэмшлийн зам талбай, гэр хорооллын айл өрхүүдэд эко ариун цэврийн байгууламж байгуулах" ажлын гүйцэтгэл, чанарт хяналт тавих.				Аймгийн Засаг даргын А/315 дугаартай захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулан ГХБХБГ-тай хамтарч "Нийтийн эзэмшлийн зам талбай, гэр хорооллын айл өрхүүдэд эко ариун цэврийн байгууламж байгуулах" ажлын гүйцэтгэл, чанарт хяналт тавин ажиллаж аймгийн Засаг даргын Тамгын газрын зөвлөлийн хуралд танилцуулсан.	2025.04.24-2025.05.06	100%

3	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Бүсчилсэн хөгжил, төрийн албаны манлайлал Хангайн бүсийн зөвлөгөөн зохион байгуулах				Бүсчилсэн хөгжил, төрийн албаны манлайлал сэдэвт Хангайн бүсийн зөвлөгөөн зохион байгуулах ажлын хэсэгт орж ажиллан бэлтгэл ажил бүрэн хангаж, 2025 оны 05 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулан ажилласан.	2025.05.14- 2025.05.15	100%
---	---	--	--	--	---	---------------------------	------

ТАЙЛАН ГАРГАСАН:

ДЭД БҮТЦИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)


Д.НАРАНБААТАР / /
(Нэр, гарын үсэг)

2025.06.09
(Огноо)